





# АГУУЛГА

## Эрхэм зорилго

### Алсын хараа

### Үнэт зүйлс

Гүйцэтгэх захирлын илгээлт  
Компанийн тухай  
Хөгжлийн төлөөх 10 жил  
2021 оны онцлох үйл явдлууд  
2021 оны гол үзүүлэлтүүд  
Зээлийн үйл ажиллагаа  
Санхүүгийн гол үзүүлэлтүүд

## Компанийн засаглал

Хувьцаа эзэмшигчдийн хурал  
Хувьцаа эзэмшигчдийн бүтэц  
Хувьцааны арилжаа  
Ногдол ашгийн тайлан

## Төлөөлөн Удирдах Зөвлөл

ТУЗ-ын бүтэц, танилцуулга (Дарга, Ердийн болон Хараат бус гишүүд)  
ТУЗ-ийн хурал, 2021 онд шийдвэрлэсэн асуудал  
ТУЗ-ийн Хороодын чиг үүрэг, танилцуулга

## Финтект суурилсан үйлчилгээний үзүүлэлт

Ард Апп  
Fast Cash зээл  
Виртуал хөрөнгө барьцаалсан зээл  
АрдКидс Апп

## Хүний нөөц

Хүний нөөцийн бодлого  
Удирдлагын багийн танилцуулга

## Нийгмийн хариуцлага

Банк бус санхүүгийн байгууллагын зах зээл  
Хараат бус аудитын тайлан  
Хамтрагч байгууллагууд



## Гүйцэтгэх захирлын илгээлт

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид, харилцагчид, бизнесийн түншүүд, хамтран ажиллагсад та бүхнийхээ амар мэндийг эрье.

Улиран одогч 2021 онд Ард Кредит ББСБ ХК-ийн 10 жилийн ойн баяр тохиож, түүхэндээ өндөр өсөлт үзүүлсэн өрнүүн жилийг бид хамтдаа үдлээ.

Цар тахлын онцгой цаг үед хямралыг боломж болгон ажиллахыг зорьсны үр дүнд бид Монголын Хөрөнгийн Биржийн I ангилалд дэвшээд зогсохгүй нээлттэй компани болсон цагаасаа ТОП-20 индекст тасралтгүй 3 дахь жилдээ дараалан багтаж, компанийн (MSE:ADB) нэгж хувьцааны үнэ түүхэн дээд ханш болох 351.12 төгрөгт хүрч, жилийн туршид нийт 19.7 тэрбум төгрөгийн 106.8 сая ширхэг хувьцаа арилжаалагджээ.

Үндсэн үйл ажиллагааны хувьд, зээлийн багцаа 20.3 тэрбум төгрөгөөс 36.6 тэрбум төгрөгт хүргэж, 3.9 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна. Ард Апп хэрэглэгчдийн тоо 357 мянгаас 1

саяд хүрч 3.4 дахин өсөлт үзүүлсэн бол хувьцаа эзэмшигчдийн тоо оны эхэнд 2,139 байснаас 6.4 дахин нэмэгдэж 13,702-д хүрсэн байна.

Өнгөрөгч оныг товч дүгнэхэд, бид гадаад, дотоод хамтын ажиллагаагаа өргөжүүлэн тэлэх, харилцагч нарынхаа санхүүгийн хэрэгцээг тасралтгүй, найдвартай хангах, технологийн сайжруулалт хийх, виртуал хөрөнгө барьцаалсан зээлийн бүтээгдэхүүнийг гаргах, хүүхдэд тусгайлан зориулсан АрдКидс санхүүгийн аппликейшнийг зах зээлд нэвтрүүлэх зэрэг шинэ санаачилгуудаараа салбартаа түйвээлт хийж манлайлан ажиллалаа.

Салбарын хөгжлийг түүчээлэх Алсын хараа бүхий Ард Кредит ББСБ ХК нь 2022 ондоо төр засгийн бодлогын өөрчлөлтүүдтэй уялдуулан үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн тэлэхээс гадна бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ төрөлжилт, сайжруулалтад онцгой анхаарч Монгол улсад анх удаа үйлдвэрлэгч, бизнес эрхлэгч, эцсийн хэрэглэгчийг

холбосон нийлүүлэлтийн гинжин хэлхээний шинэ төрлийн санхүүжилтийн үйлчилгээг нэвтрүүлэхээр судалж байна.

Амжилтаа ахиулсаар ирсэн түүхэн он цагийн хэлхээнд бидэнтэй хамт байсан нийт хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчид, бизнесийн түншүүд, хамтран ажиллагсад та бүхэндээ сайн сайхан бүхнийг хүсэн ерөөж, 2022 он бидний дараагийн 10 жилийн хуудсыг нээсэн, үсрэнгүй амжилтыг бататгасан жил байх болно гэдэгт итгэлтэй байгаагаа дуулгахад таатай байна.



Хүндэтгэсэн,  
**Гүйцэтгэх захирал**  
**Г.Тэлмэн**



## Эрхэм зорилго

Ирээдүйн ур чадвар, технологийг цаг хугацааны товчлолоор авчирч, тогтвортой хөгжлийг түргэтгэж, өндөр өгөөжийг бий болгоно

## Алсын Хараа

Салбарын хөгжлийг түүчээлнэ

## Үнэт зүйлс

Хамтдаа хуваалцах

Тогтвортой хөгжих

Хүлээлтээс давж үйлчлэх

Хүртээмжтэй, тэгш оролцоог бүрдүүлэх

Ёс зүйтэй байх

# ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ 10 ЖИЛ

## 2011

Интергрупп Интернэйшнл ХХК-ийн хөрөнгө оруулалтаар үүсгэн байгуулагдав.

---

## НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИ

## 2018

Монголын Хөрөнгийн Бирж, Санхүүгийн Зохицуулах Хорооноос IPO хийх зөвшөөрөл аван үнэт цаасаа бүртгүүлэв.

## 2019

I улиралд хувьцаагаа олон нийтэд нээлттэй санал болгож, анхдагч зах зээлийн арилжааны захиалга төлөвлөснөөс 299 хувь даван биелэв. Олон нийтээс 5.3 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлж, 1,500 гаруй шинэ хувьцаа эзэмшигчтэй нээлттэй хувьцаат компани болов.

2019 оны цэвэр ашиг болох 2.2 тэрбум төгрөгийн 50% буюу 1.18 тэрбум төгрөгийг хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг хэлбэрээр хуваарилахаар шийдвэрлэж 4 сарын 30-нд Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй хувьцаат компаниудаас хамгийн түрүүнд ногдол ашгаа хувьцаа эзэмшигчдэдээ тараав.

## 2020

2020 оны цэвэр ашгаас 1 тэрбум төгрөгийг 10,323 хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хэлбэрээр тараав.

## 2021

Монголын Хөрөнгийн Биржийн хувьцаат компанийн I ангилалд дэвшин оров.

Нээлттэй хувьцаат компани болсноос хойш жил бүр дараалан ТОП-20 индекст багтаж, хувьцаа эзэмшигчдийн хурлаа танхим болон цахимаар жил бүр 80%-аас дээш ирцтэйгээр зохион байгуулж ажилласан байна. 2021 онд хувьцаа эзэмшигчдийн тоо 13 мянгад хүрснээр хамгийн олон хувьцаа эзэмшигчтэй ББСБ болоод байна.

---

## ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

## 2014

Санхүүгийн Зохицуулах Хорооноос Итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл авав.

## 2017

Санхүүгийн Зохицуулах Хорооноос Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах тусгай зөвшөөрөл авч, үйл ажиллагаагаа өргөжүүлэн ажиллав.



**2018**

Санхүүгийн Зохицуулах Хорооноос Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээний тусгай зөвшөөрөл авав.

**2020**

Монголбанкнаас Ард Кредит ББСБ ХК-д Цахим мөнгө гаргах, төлбөрийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл олгосноор банкны төлбөр тооцооны үйлчилгээнд оролцож эхлэв.

**БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ****2014**

Бичил Санхүүгийн Хөгжлийн Сантай хамтран ажиллаж, амьжиргааны түвшнээс доогуур орлоготой айл өрхүүдэд хөнгөлөлттэй зээл олгож эхлэв.

**2017**

Салбартаа анхлан Кредит картын үйлчилгээг амжилттай нэвтрүүлэв.

**2018**

Овердрафтын зээлийн бүтээгдэхүүнийг амжилттай нэвтрүүлэв.

Хүүгүй, барьцаагүй зээлийг зах зээлд амжилттай нэвтрүүлэв.

ББСБ-уудаас салбартаа анхлан хувьцаа барьцаалсан зээлийн бүтээгдэхүүнийг зах зээлд амжилттай нэвтрүүлэв.

Санхүүгийн бүх төрлийн үйлчилгээг нэг дороос үзүүлэх Ард Аппын анхны хувилбарыг олон нийтэд танилцуулав.

Ард Санхүүгийн Нэгдлийн санхүүгийн цогц үйлчилгээ үзүүлэх салбар Сэнтрал Тауэрт нээгдэж, Санхүүгийн Зохицуулах Хорооноос салбарын тусгай зөвшөөрөл аван үйл ажиллагаагаа явуулж эхлэв.

**2019**

Ард Аппын 2 дахь хувилбарыг нэвтрүүлэв.

Fast Cash хиймэл оюун ухаанд суурилсан цахим зээлийн үйлчилгээг Ард Аппаар дамжуулан олгож эхлэв.

**2020**

EuroGiro олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээг Монгол Шуудан ХК-тай хамтран нэвтрүүлж, харилцагчдадаа дэлхийн 56 улсаас хамгийн бага шимтгэлтэй мөнгөн гуйвуулга хийх боломжийг нээв. АСН+ (Автомат Клиринг Хаус) банк хоорондын шууд гүйлгээний системийг амжилттай нэвтрүүлэв.

**2021**

Анхны виртуал хөрөнгө барьцаалсан зээлийн үйлчилгээг нэвтрүүлэв.

АрдКидс хүүхдэд зориулсан анхны аппликейшнийг зах зээлд нэвтрүүлэв.



## ХАМТЫН АЖИЛЛАГАА

### 2014

Бичил Санхүүгийн Хөгжлийн сантай хамтран ажиллаж иргэдэд хөнгөлөлттэй зээл олгож эхлэв.

### 2017

ГрэйпСити Монгол ХХК-тай стратегийн түвшинд хамтран ажиллахаар болж, Поларис үндсэн банкны систем болон Мост Мони үйлчилгээг нэвтрүүлэх гэрээ байгууллаа.

### 2019

Япон улсын Крауд Кредит хөрөнгө оруулалтын сантай хийсэн 5 сая долларын санхүүжилтийн гэрээний дагуу санхүүжилтүүдийг хүлээн авч, эргэн төлөлтүүдийг амжилттай гүйцэтгэн ажиллаж байна.

### 2019

Дэлхийн 36 улсын 100 гаруй байгууллагыг эгнээндээ нэгтгэсэн, Варшав хотод байршилтай ""Бичил Санхүүгийн Төв""-өөс зохион байгуулсан хурлын Алтан спонсороор ажиллаж, баг, хамт олноороо амжилттай оролцсон. Гаднын олон зочид хуран чуулсан уг хурлаар Ард Апп-ыг олон улсын хөрөнгө оруулагчдад албан ёсоор танилцуулав.

### 2020

Жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих BEST хөтөлбөрийн хүрээнд Хөгжлийн Шийдэл ТББ-тай хамтран ажиллах санамж бичиг байгуулж зээлдэгчдийн боловсролын чиглэлээр ажиллаж эхлэв.

# 2021 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

Ард Апп хэрэглэгчийн тоо **1 саяд хүрэв.**

Хөрөнгө оруулагчдад зориулж **"Fast Cash White"** хөнгөлөлттэй зээлийг нэвтрүүлэв.

2020 оны цэвэр ашгаас **1 тэрбум төгрөгийг** 10,323 хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хэлбэрээр тараав. Монголын Хөрөнгийн Биржийн ТОП-20 индекст дахин багтав.

**Ард Аппын шинэчилсэн 4 дэх хувилбарыг** олон нийтэд танилцуулав.

Монголын Банкны Холбооны **гишүүн байгууллага болов.**

**"NO ONE LEFT BEHIND. TOGETHER"** төслийг Монголын Хараагүйчүүдийн Үндэсний Холбоо, JCI Централ ТББ-тай хамтран хэрэгжүүлэв.

Ард Кредит ББСБ ХК **13 мянга гаруй хувьцаа эзэмшигчтэй** болсноор хамгийн олон хувьцаа эзэмшигчтэй ББСБ болов.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаа 86.31 хувийн ирцтэйгээр **цахимаар зохион байгуулав.**

Хувьцаа эзэмшигчдэдээ 1.3 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий **5.8 сая ширхэг АрдКойныг урамшууллаар олгов.**

**Япон улсын Крауд Кредит сантай** хамтын ажиллагааг сайжруулж санхүүжилтийн өртгийг бууруулж, хэмжээг нэмэгдүүлэв.

Монголын Хөрөнгийн Биржийн Хувьцаат компанийн **I ангилалд дэвшин оров.**

Ард Аппад итгэлцэл, тэтгэврийн хуримтлал барьцаалсан зээл, виртуал хөрөнгө барьцаалсан зээл зэрэг үйлчилгээг **шинээр нэвтрүүлэв.**

**"Илгээлтийн эзэд-Санхүүгийн боловсрол түгээх төсөл"**-ийг хамтран хэрэгжүүлэв.

**"Цахим Үндэстэн 2021"** арга хэмжээнд Алтан спонсорор оролцож, бүтээгдэхүүн үйлчилгээгээ олон нийтэд танилцуулав.

Монголд анх удаа хүүхдийн санхүүгийн хэрэгцээнд зориулсан **АрдКидс Аппликейшнийг** нэвтрүүлж, олон нийтэд танилцуулав.

Улаанбаатар хотын төв цэг болох **Төв Шууданд салбараа нээж**, санхүүгийн бүх төрлийн үйлчилгээг нэг цэгээс үзүүлж эхлэв.

**"Frontier Fintech Summit 2021"** арга хэмжээнд ерөнхий спонсорор оролцов.

# 2021 ОНЫ ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

**13,702**

Хувьцаа эзэмшигчдийн тоо

**1,012,184**

Харилцагчийн тоо

**21,243**

АрдКидс харилцагчийн тоо

**1,094,096**

Апп таталт

**₮85 тэрбум**

Олгосон зээлийн дүн

**₮36.6 тэрбум**

Зээлийн багц

**₮68.7 тэрбум**

Зээлийн эргэн төлөлт

**47,708**

Зээлдэгч

**890,787**

Зээлийн хүсэлт

**₮73.3 тэрбум**

Нийт хөрөнгө

**₮38.7 тэрбум**

Санхүүжилт

**₮3.9 тэрбум**

Цэвэр ашиг

# ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2021 онд нийгэм, эдийн засгийн амьдралд үзүүлэх цар тахлын нөлөө хэвээр байсан ч бид жилийн эцэс гэхэд нийт зээлийн багцаа 36.6 тэрбум төгрөгт хүргэж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 81 хувиар өсгөлөө. Нийт олгосон зээлийн 71 хувийг онлайн зээл, 23.3 хувийг бичил, жижиг дунд бизнесийн зээл, үлдэх 5.7 хувийг хэрэглээний зээлийн олголт бүрдүүлсэн байна. Нийт 65,790 иргэн, аж ахуйн нэгжид 85.0 тэрбум төгрөгийн зээл олгосон нь өмнөх онтой харьцуулахад зээл олголт 2 дахин өссөн үзүүлэлт юм.

2021 оны эцэст эрсдэлтэй зээлийн нийт багцад эзлэх хувь 9.2 хувь, чанаргүй зээлийн нийт багцад эзлэх хувь 7.0 хувь байгаа нь өмнөх оны мөн үеэс 3.59, 2.43 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байлаа. ББСБ-ын салбарын 2021 оны III улирлын эрсдэлтэй зээл болон чанаргүй зээлийн үзүүлэлттэй харьцуулахад 2 хувь, 1.3 хувиар тус тус бага байна. Зээлийн эрсдэлийн санг өмнөх оноос 83 хувиар өсгөж, 2,468.1 сая төгрөгт хүргэсэн нь нийт чанаргүй зээлийн 96 хувийг хангах түвшинд хүрлээ.

2021 онд зөвхөн Улаанбаатар хотод төдийгүй хөдөө орон нутгийн иргэдэд онлайн зээлийн үйлчилгээгээ хүргэж, цар тахлын улмаас бизнес нь хүндэрсэн зээлдэгчдэдээ зээлийн хүүг бууруулах, хугацааг сунгах зэргээр дэмжиж ажиллалаа.













Үзүүлэлт (сая төгрөг)	2020	2021	Өсөлтийн хувь
Олгосон зээлийн тоо	42,658	65,790	154%
Олгосон зээлийн дүн	42,113.7	84,990.9	202%
Нийт идэвхтэй зээлийн тоо	18,803	23,385	124%
Нийт зээлийн багц	20,297	36,646	181%
PAR	12.79%	9.20%	
NPL	9.45%	7.02%	
Нэг зээлийн дундаж үлдэгдэл	1,080	1,567	145%
Зээлийн эргэн төлөлтийн дүн (үндсэн зээл)	39,048	68,668	176%
Зээлийн хүсэлтийн тоо	537,229	890,787	166%
Зээлийн жигнэсэн дундаж хүү	39.4%	35.9%	



# САНХҮҮГИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД







# КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

## Хувьцаа эзэмшигчдийн хурал

Ард Кредит ББСБ ХК нь Монголын Хөрөнгийн Биржийн хувьцааны I ангилалд 2021 оны 08 сарын 30-ны өдрөөс шилжсэн бөгөөд 2020 оны 12 сарын 31-ний өдрөөр 2,139 хувьцаа эзэмшигчтэй байсан бол 2021 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар 13,702 хувьцаа эзэмшигчтэй болсон байна.


Ард Кредит ББСБ ХК-ийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байх бөгөөд түүний чөлөө цагт компанийн үйл ажиллагааг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас томилогдсон 9 гишүүний бүрэлдэхүүнтэй Төлөөлөн Удирдах Зөвлөл удирдана. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, компанийг өөрчлөн байгуулах, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнийг сонгох, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах, компанийн хэлбэрийг өөрчлөх зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэдэг.

Компани 2021 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг [live.ard.mn](http://live.ard.mn) сайтаар зохион байгуулж 280,000,000 ширхэг саналын эрх бүхий хувьцаа эзэмшигчид оролцож, 87.54 хувийн ирцтэйгээр хуралдан Ард Кредит ББСБ ХК-ийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах, компанийн дүрэмд өөрчлөлт оруулах, Төлөөлөн Удирдах зөвлөлийн гишүүнийг нөхөн томилох шийдвэр тус тус гаргасан юм.



## Хувьцаа эзэмшигчдийн бүтэц

Хувьцаа эзэмшигч	2021.12.31	Хувь
1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК	113,593,498	40.57%
2. С.Гэрэлтуяа	27,552,061	9.84%
3. Х.Батхишиг	14,426,329	5.15%
4. Ардын Тэтгэврийн Данс ХХК	14,419,655	5.15%
5. С.Оргил	11,658,223	4.16%
6. Г.Бат-Эрдэнэ	11,648,223	4.16%
7. Ард Бит ХХК	11,221,109	4.01%
8. И Ай Ти ХХК	7,108,545	2.54%
9. Н.Мөнхнасан	7,058,824	2.52%
10. А.Сүхдорж	5,086,580	1.82%
Топ хувьцаа эзэмшигчид	223,773,047	79.92%
Бусад хувьцаа эзэмшигчид	56,226,953	20.08%
Эргэлтэнд байгаа хувьцаа	280,000,000	100.00%
Нийт зарласан хувьцаа	280,000,000	100.00%
<b>Хувьцаа эзэмшигчдийн тоо</b>	<b>13,702</b>	



### Хувьцааны арилжаа

Хаалтын ханш	₮219.93
Дээд болон доод үнэ	₮77-₮351
Нийт эргэлтэнд байгаа хувьцааны тоо	280,000,000
Нийт арилжааны дүн	₮19.7 тэрбум
Зах зээлийн үнэлгээ	₮61.6 тэрбум
Арилжаалагдсан хувьцааны тоо	106.8 сая ширхэг
EPS (TTM)	₮15.0
P/E (TTM)	14.7x
P/B	2.3x

### Ногдол ашгийн тайлан

Ард Кредит ББСБ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2021 оны 2 сарын 11-ний өдрийн 2021/08 тогтоол, 2021 оны 4 сарын 13-ны

өдрийн 2021/12 тоот тогтоолуудаар компанийн 2020 оны жилийн эцсийн цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчдэдээ нэгж хувьцаанд

3.57 төгрөг буюу цэвэр ашгийн 80.6 хувь болох 1 тэрбум төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэсэн.

# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ



## ТУЗ-ын бүтэц, танилцуулга (Дарга, Ердийн болон Хараат бус гишүүд)

Ард Кредит ББСБ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (Цаашид "ТУЗ" гэх) нь Компанийн стратегийг тодорхойлж, хянах, үйл ажиллагааны тайлан батлах, Хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хангах үүднээс шийдвэр гаргах, жилийн

төсөв бизнес төлөвлөгөөг батлах зэрэг Компанийн тухай хууль, болон дүрэмд заасан чиг үүргийнхээ хүрээнд шийдвэр гаргаж ажилладаг.

Мөн Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1-т заасны дагуу Ард Кредит ББСБ ХК-ийн ТУЗ нь 9-11 гишүүнтэй байхаар дүрэмдээ тусгаж, өнөөгийн байдлаар 6 ердийн, 3 хараат бус гишүүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.



**Чулууны Ганхуяг**  
ТУЗ-ийн дарга



**Одончимэдийн Одбаяр**  
Ердийн гишүүн



**Чулууны Ганзориг**  
Ердийн гишүүн



**Гэрэлтийн Тэлмэн**  
Ердийн гишүүн



**Хишигдоржийн Батхишиг**  
Ердийн гишүүн



**Барамсайн Ганбат**  
Ердийн гишүүн



**Ванчигийн Ганзориг**  
Хараат бус гишүүн



**Чулуунзоригтийн Чинзоригт**  
Хараат бус гишүүн



**Батсүрэнгийн Солонго**  
Хараат бус гишүүн



### ТУЗ-ийн хурал, 2021 онд шийдвэрлэсэн асуудал

---

Ард Кредит ББСБ ХК-ийн ТУЗ нь 2021 онд 4 удаа ээлжит, 53 удаа эчнээ хурал зохион байгуулсан ба хурлын хүрээнд 72 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж ажилласан байна. Тус онд ТУЗ-өөс гаргасан онцлог шийдвэрүүдээс дурдвал 2020 оны цэвэр ашгаас 1.0 тэрбум

төгрөгийг ногдол ашиг хэлбэрээр тараах, Хаалттай бонд гаргах, Халаасны хувьцаа эргэлтэд гаргах, Монголбанкнаас карт гаргагчийн тусгай зөвшөөрөл авах шийдвэр, Компанийн үйл ажиллагаа өргөжин тэлж байгаатай холбогдуулан 2 салбар байгуулах, 2022 оны төсөв,

бизнес төлөвлөгөөг батлах зэрэг компанийн үйл ажиллагааг зөв зохистой удирдахад нөлөөлөхүйц томоохон шийдвэрүүдийг гаргаж ажиллажээ.

### ТУЗ-ийн Хороодын чиг үүрэг, танилцуулга

---

Ард Кредит ББСБ ХК-ийн ТУЗ нь компанийн үйл ажиллагааг үр өгөөжтэй, байнгын, мэргэжлийн түвшинд удирдах зорилгоор Дотоод

аудитын хороо, Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо, Санхүү, эрсдэл, зээлийн хороодтой байх бөгөөд уг Хороод нь

Компанийн тухай хуульд зааснаар ТУЗ-өөр хэлэлцэх асуудалтай холбоотой зөвлөмж гарган ТУЗ-д танилцуулж ажилладаг.

### Дотоод аудитын хороо

---

Дотоод аудитын хороо нь компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын

болон эрсдэлийн үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих, аудитын

байгууллагыг сонгон шалгаруулах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.



**Бүрэлдэхүүн:** Хорооны дарга ТУЗ-ийн хараат бус гишүүн В.Ганзориг

**Хорооны гишүүд:**

ТУЗ-ийн хараат бус гишүүн Ч.Чинзоригт

ТУЗ-ийн ердийн гишүүн Б.Ганбат

**Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо**

Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны гол зорилго нь компанийн ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, эрх бүхий албан тушаалтнуудыг сонгон шалгаруулах, тэдгээрийн цалин урамшууллын бодлогыг тодорхойлох асуудлыг хууль, дүрэм, журамд нийцүүлэн санал, дүгнэлт гаргах чиглэлээр ТУЗ-ийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд туслахад оршдог.

**Бүрэлдэхүүн:** Хорооны дарга ТУЗ-ийн ердийн гишүүн О.Одбаяр

**Хорооны гишүүд:**

ТУЗ-ийн хараат бус гишүүн В.Ганзориг

ТУЗ-ийн ердийн гишүүн Х.Батхишиг

ТУЗ-ийн хараат бус гишүүн Ч.Чинзоригт

ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Солонго

**Санхүү, эрсдэл, зээлийн хороо**

Санхүү, эрсдэл, зээлийн хороо нь компанийн стратеги төлөвлөгөө, зээлийн үйл ажиллагаанд баримтлах бодлогыг боловсруулж, ТУЗ-д танилцуулан батлуулах, компанийн хувьцааны үнэ цэнийг дээшлүүлэх, зээлийн эрсдэлийг бууруулахад хяналт тавьж ажиллах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна

**Бүрэлдэхүүн:** Хорооны дарга ТУЗ-ийн гишүүн Ч.Ганзориг

**Хорооны гишүүд:**

ТУЗ-ийн ердийн гишүүн Г.Тэлмэн

ТУЗ-ийн ердийн гишүүн Б.Ганбат

# ФИНТЕКТ СУУРИЛСАН ГОЛ ҮЙЛЧИЛГЭЭ



Ард Апп нь санхүүгийн төрлийн бүх төрлийн үйлчилгээг нэг дороос үзүүлэх цогц Аппликейшн юм.

## Боломжууд

Цахим зээл

Даатгал

Хөрөнгө оруулалт


Онлайн дэлгүүр

Хуримтлал

АрдКойн

Апп таталт

# 1,094,096



Харилцагчийн тоо

1,012,184

### Fast Cash зээл

Fast Cash зээл нь харилцагчийн мэдээлэлд үндэслэн хиймэл оюуны тусламжтайгаар хамгийн хурдан хугацаанд, хамгийн өндөр зээлийн тооцооллыг хийдэг цахим зээлийн үйлчилгээ юм.

10 сая төгрөг хүртэлх зээлийг 5 минутын дотор харилцагчаас ямар нэг барьцаа хөрөнгө шаардахгүйгээр шийддэг бөгөөд бусад финтек зээлийн үйлчилгээтэй харьцуулахад хугацааны хувьд хамгийн урт буюу 6 сар, зээлийн эргэн төлөлтөө сунгах зэрэг уян хатан нөхцөлтэй юм.

**Зээлдэгчийн тоо - 20,525**

**Зээл олголтын тоо - 57,985**

**Зээл олголтын дүн - 53.9 тэрбум**

---

### Виртуал хөрөнгө барьцаалсан зээл

АрдКойн барьцаалсан зээл нь санхүүгийн салбарт анхны виртуал хөрөнгө барьцаалсан зээлийн үйлчилгээ болсноороо онцлогтой юм. Энэхүү зээлийн үйлчилгээ нэвтэрснээр АрдКойн эзэмшигчид шаардлагатай үедээ санхүүгийн хэрэгцээгээ шуурхай шийдэх боломжтой цахим зээлийн үйлчилгээ юм.

**Зээлдэгчийн тоо - 2,860**

**Зээл олголтын тоо - 4,977**

**Зээл олголтын дүн - 3.8 тэрбум төгрөг**

---



## АрдКидс Апп

АрдКидс Апп нь хүүхдийн санхүүгийн хэрэгцээг цогцоор нь хангасан Монголын анхны хүүхдэд тусгайлан зориулсан аппликейшн юм. АрдКидс Аппыг хүүхдэд багаас нь санхүүгийн боловсрол олгох, санхүүгийн харилцаанд зөв зохистой бие даан оролцож сурахад зориулан 2021 оны 9 дүгээр сард нэвтрүүлсэн юм. Оны эцэст буюу зах зээлд нэвтрүүлснээс хойш ердөө 3 сарын дотор 22 мянга орчим хэрэглэгчидтэй болж чадсан билээ.

АрдКидс Апп хэрэглээнд нэвтэрснээр хүүхдүүд бүх төрлийн гүйлгээг (банк хооронд, утасны дугаараар, Qpay) бие даан хийх, хувьцаа, хадгаламж, АрдКойныхоо дансыг өөрөө хянах, хадгаламждаа орлого нэмэх, зөвхөн хүүхдэд зориулсан АрдШоп онлайн дэлгүүрээс бараа бүтээгдэхүүн худалдан авах, гар утасны нэгжээ цэнэглэх, кино тасалбараа захиалах зэрэг олон боломжуудыг эдлэх болсноороо онцлог билээ.

Үүнээс гадна АрдКидсын хэрэглэгчдэд зориулж Ард Академи санхүү, хөрөнгө оруулалтын мэдлэгийг олгож байгаа нь бахархуштай юм.



Харилцагчийн тоо - 21,243

# ХҮНИЙ НӨӨЦ

Чадварлаг, цомхон, бүтээмж өндөртэй, алдаанаасаа тасралтгүй суралцдаг хүний нөөцөөр багаа бүрдүүлэн ажиллахыг зорьдог бидний хувьд 2021 онд цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан ажлын байранд шаардлагатай зохион байгуулалтыг цаг алдалгүй хийж нийт ажилтнууд, харилцагч нарынхаа эрүүл мэнд, аюулгүй байдлыг дээд зэргээр ханган ажиллах, тэгш эрхийн бодлогыг хэрэгжүүлэхэд онцгой анхаарал хандуулан ажиллалаа.

Нийт ажиллагсдадаа 20 сая төгрөгийн нөхөн олговор бүхий эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгалд хамруулах, Ковид-19 халдвараас

сэргийлэх ажлуудыг үе шаттай хэрэгжүүлж, санхүүгийн болон биет тусламж үзүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүллээ.

Мөн ажлын байранд тэгш эрхийн бодлогыг урт хугацаанд хэрэгжүүлэх зорилт тавьснаар 2021 оны эхний улиралд Харилцагчийн үйлчилгээний төвд цар тахлын нөлөөллөөр өрхийн орлого нь багассан, тодорхой шалтгааны улмаас бүтэн цагаар ажил эрхлэх боломжгүй болсон ээжүүд, оюутан залуус, хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй хамтран ажилласан билээ.

Монголын Хараагүйчүүдийн Үндэсний Холбоо, JCI Central байгууллагуудтай хамтран “No One left behind. together” төслийг хэрэгжүүлснээр Харилцагчийн үйлчилгээний төвд 4 ялгаатай хөгжилтэй иргэнийг шинээр ажилд авахад дэмжлэг үзүүлэв. Ард Кредит ББСБ ХК нь 2021 оны төгсгөлд нийт 36 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж, шинээр 9 ажлын байрыг бий болгож, хамтран ажилласан байгууллагуудад 63 хүнийг ажлын байраар хангаж ажиллахад дэмжлэг үзүүлэв.





Удирдлагын багийн танилцуулга



Гүйцэтгэх захирал  
Г.Тэлмэн



Үйл ажиллагаа  
эрхэлсэн захирал  
М.Номин-Эрдэнэ



Зээл эрхэлсэн захирал  
Б.Баттөгс



Санхүү эрхэлсэн захирал  
Х.Билгүүн



# НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

Нийгмийн хариуцлагын хүрээнд “Ид Шидийн Орон” хүүхэд хамгаалал, хөгжлийн төвд 26 хүүхдийн багтаамжтай Nissan Civilian автобусыг хандивлаж, Ковид-19 цар тахлын үед улаан бүсэд ажиллаж байсан 100 сувилагчид 100 сая төгрөгийн тусламжийг үзүүлж, Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” хөдөлгөөнд нэгдэж Ардын төгөлийг хамтран байгууллаа.

Ялгаатай хөгжилтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, тэдний санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх, ажил олгогчдын хэвшмэл сэтгэлгээг өөрчлөх зорилгоор “NO ONE LEFT BEHIND. TOGETHER” төслийг Монголын Хараагүйчүүдийн Үндэсний Холбоо, JCI Централ ТББ-тай хамтран хэрэгжүүлэв. Үр дүнд Ард Санхүүгийн Нэгдэл болон түүний охин компаниудад ажиллах ялгаатай хөгжилтэй ажиллагсдын тоо нэмэгдэж, Хувьцаа эзэмшигчдийн хурлаа анх удаа сонсголын

бэрхшээлтэй иргэдэд зориулан дохионы хэлмэртэй зохион байгуулав.

Мөн хөл хорионы хугацаанд 40 мянган гэрээг цахимаар баталгаажуулснаар 729 мод устах эрсдэлийг бууруулж, салбаргүй үйлчилгээний бодлого баримталж, санхүүгийн олон төрлийн үйлчилгээг цахимаар хүргэснээр 1 сая харилцагчид шууд болон шууд бусаар санхүү, мөнгө, цаг хугацаагаа үлэмж хэмжээгээр хэмнэж чадсан юм.





# ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН

Ковид-19 цар тахлын улмаас 2020 онд 5.3 хувиар агшсан манай улсын эдийн засаг 2021 онд гадаад худалдааны тээвэр логистикийн асуудлаас үүдэн эдийн засгийн өсөлт хүлээлтээс харьцангуй доогуур буюу 1.4 хувьтай гарлаа.

Эдийн засгийн үйл ажиллагааны салбараар нь авч үзвэл өмнөх оноос:

- Барилга 32.7%, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа 16.7%, хөдөө аж ахуйн салбар 5.5%-иар тус тус бууралттай;
- Бүтээгдэхүүний цэвэр татвар 12.2%, мэдээлэл холбоо 12.2%, санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа 7.2%, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа 3.9%-иар тус тус өссөн байна.

Урд хөрш БНХАУ хилээ хаасантай холбоотойгоор 2020 онтой харьцуулахад экспорт биет хэмжээгээрээ зэсийн баяжмал 11%-иар, төмрийн хүдэр 15%-иар, нүүрс 44%-иар тус тус буурсан ч дэлхийн зах зээл дээр эрдэс бүтээгдэхүүний үнэ өссөн нь салбарын гүйцэтгэлийн орлого 111% болоход нөлөөлжээ.


## Инфляц

2021 оны анхаарлын төвд байсан макро эдийн засгийн үзүүлэлт бол 13.4%-тай гарсан инфляц байлаа. Ийнхүү инфляц өндөр гарахад дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнийн өсөлт, хил дамнасан тээвэрлэлт, логистик, хил дээрх саатлууд голлон нөлөөлжээ.

Барааны бүлгээр авч үзвэл:

Бензин 47.5%, хүнс 21%, орон сууц 15.3%, гэр ахуй 9.5%, эм тариа 7.5% тус тус өссөн байна.





Эх сурвалж: Монголбанк

## Төсөв, мөнгөний бодлого

Монгол улсын Засгийн газар 2021 оны 2 сарын 17-ний өдөр Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөөг баталж эдийн засгаа эрчимжүүлэх шийдвэрийг гаргасан бөгөөд тус хөтөлбөрийн хүрээнд 2 их наядын зээл жилийн 3% хүүтэй олгосон. Үүний үр дүнд банкны салбарын нийт зээлийн багц 21.3%-иар тэлж 20.7 их наяд төгрөгт хүрсэн байна.


Энэхүү 10 их наядын цогц төлөвлөгөөнд жижиг дунд үйлдвэрлэл, стратегийн ач холбогдол бүхий томоохон төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилт, Монгол банкны репо санхүүжилтийг 2 дахин нэмэгдүүлэх, ХАА-н үйлдвэрлэл, малчдыг дэмжих зэрэгт голлон анхаарлаа хандуулсан.

Төрөөс төсөв болон мөнгөний зөөлөн бодлого баримталсны үндсэнд банкны салбарт эх үүсвэр хангалттай байснаар төгрөгийн хадгаламжийн

дундаж хүү жилийн 7 хувьд хүрч, улмаар зээлийн хүү жилийн 14 хувь руу буурлаа. Ийнхүү хадгаламжийн бодит хүү -6% байгаа нь иргэд альтернатив санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах сонирхлыг нэмэгдүүлж хөрөнгийн зах зээлийн хөгжилд эерэг нөлөөг үзүүллээ.

2021 онд хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээ өмнөх оноос 98%-иар өсөж, 6 их наяд төгрөгт хүрснээр дэлхийн хамгийн өндөр өсөлттэй зах зээлийн нэгээр тодорсон бол дундаж ТОП-20 индекс 130%-иар өссөн байна.

# ХАРААТ БУС АУДИТЫН ТАЙЛАН



"ГРАНТ ТОРНТОН АУДИТ" ХХК  
Аудит, татвар, зөвлөх үйлчилгээний  
дэлхийн сүлжээний бие даасан фирм

## Хураангуй санхүүгийн тайлангийн талаарх Хараат бус аудиторын дүгнэлт

Дэлхий даяа Т.дунгар, 67-6800  
Сүржин, Туркменистан дүүрэг, Т.р.  
Маски, 3300-3300  
Маски улс  
Т + 993 70 100744  
+ 993 70 100750

Suite 7000, 5 E. UNEMO Drive,  
SARAKATA District 3, Dordoykh  
16100, Mongolia  
Т + 976 70 100744  
+ 976 70 100750

"Ард кредит ББСБ" ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд:

### Дүгнэлт

Бид "Ард кредит ББСБ" ХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-нээх санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр дуусгаар болон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн жорлолын тайлан, мөнгөн туйлгээний тайланг (дэлгэд хамтад нь "хураангуй санхүүгийн тайлан" гэх) 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгаар болон аудитын тайлангаас хураангуйлан авч батлсан болно.

Бидний дүгнэлтээр, энэхүү хураангуй санхүүгийн тайлан нь Санхүүгийн тайлангачдын олон улсын стандартад нийцүүлэн эрх бүхий байгууллагын баталсан жорлогдох дүрэм, журмын дагуу үзэн эмн. Бодотой ажлаар хийгдсэн байна.

### Хураангуй санхүүгийн тайлан

Энэхүү хураангуй санхүүгийн тайлан нь Санхүүгийн ажлааруулах хөрөнгийн 2021 оны 3 дугаар тогтоолоор батлагдсан "Бэнг бус санхүүгийн байгууллагын санхүүгийн тайлангийн мөнгө"-д шаардсан бусад тайлбар тэдгээрийг ил бүрэн агуулагүй тул "Ард кредит ББСБ" ХК-ийн аудитын тайлант бүрэн дүүрэн эрсдэлгүй болно.

Энэхүү хураангуй санхүүгийн тайланд 2022 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн мөнгө аудитын тайлангийн дүгнэлтэй хамт дүгнэлт ажлаар хийгдсэн бөгөөд өдгөөр санхүүгийн тайлан болон хураангуй санхүүгийн тайланд мөнгө аудитын тайлангийн өдрөөс хойш байнгын дараах үйл ажиллагааны үзүүлэлтгүй болно.

### Аудитлагдсан санхүүгийн тайлан ба түүнд өгсөн бидний дүгнэлт

Бид аудитлагдсан санхүүгийн тайланд эерэг дүгнэлт өгсөн. Бидний мөргөлийн үзэлтнээр аудитын гол асуудал нь эерэг эрсдэлийн сангийн тооцоололтой холбоотой асуудал байсан бөгөөд бид энэ асуудлаар дэлгэдэл өгжээгүй байна.

### Удирдлага болон Засаглах эрх мэдэл бүхий амьтадуудын Санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага

Компанийн удирдлага нь өдрөөр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлангачдын олон улсын стандартад нийцүүлэн эрх бүхий байгууллагын баталсан жорлогдох дүрэм, журмын дагуу болгох үнэн зөв болгуулах үүрэгтэй.

### Аудиторын үүрэг хариуцлага

Бидний үүрэг хариуцлага бол Аудитын олон улсын стандарт, Мөнгө улсын "Аудитын тухай" хуулийн дагуу өгсөн аудиторын үндэслэл энэхүү санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт өгж мэдэл юм.

  
Б. ОСОРБАЕВ  
УДИРДАХ ПАРТНЕР  
Монгол улс, Улаанбаатар хот  
2022 оны 3 дугаар сарын 30

"Ард кредит ББСБ" ХК  
 Хураангуй санхүүгийн тайлан  
 2021 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)

## Санхүүгийн байдлын тайлан

Мянган төгрөгөөр	2021 оны 12 сарын 31	2020 оны 12 сарын 31
<b>Хөрөнгө</b>		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	6,956,116	3,249,682
Богино хугацаат хөрөнгө оруулалт	2,997,377	89,000
Харилцагчдад олгосон зээл	34,177,792	18,949,256
Бусад санхүүгийн хөрөнгө	4,838,475	1,793,317
Бусад эргэлтийн хөрөнгө	22,604,862	3,285,543
Үндсэн хөрөнгө	1,187,391	259,291
Биет бус хөрөнгө	625,738	2,028,939
<b>Нийт хөрөнгө</b>	<b>73,387,751</b>	<b>29,655,028</b>
<b>Өр төлбөр ба эздийн өмч</b>		
<b>Өр төлбөр</b>		
Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл	19,983,388	3,532,377
Өрийн бичгээрх өглөг	561,000	3,661,000
Хойшлогдсон татварын өр төлбөр	870,640	134,219
Бусад эх үүсвэр	18,189,153	7,845,836
Бусад өр төлбөр	11,178,305	3,228,326
<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>50,782,486</b>	<b>18,401,758</b>
<b>Эздийн өмч</b>		
Эзэмшигчдийн өмч	8,142,623	6,429,896
Бусад өмч	7,053,406	976,953
Хуримтлагдсан ашиг	7,409,236	3,846,421
<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>22,605,265</b>	<b>11,253,270</b>
<b>Өр төлбөр ба эздийн өмчийн дүн</b>	<b>73,387,751</b>	<b>29,655,028</b>

"Ард кредит БРСБ" ХК  
 Хураангуй санхүүгийн тайлан  
 2021 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)

## Орлогын дэлгэрэнгүй тайлан

Мянган төгрөгөөр	2021 он	2020 он
Хүү болон түүнтэй адилтгах орлого	7,768,611	6,306,995
Хүү болон түүнтэй адилтгах зардал	(3,913,870)	(2,122,526)
<b>Хүүгийн цэвэр орлого</b>	<b>3,854,741</b>	<b>4,184,469</b>
Хүүгийн бус орлого	7,588,882	2,075,579
Хүүгийн бус зардал	(5,136,329)	(3,369,727)
<b>Цэвэр хүүгийн бус орлого</b>	<b>2,452,553</b>	<b>(1,294,148)</b>
Болзошгүй эрсдэлийн зардал	(2,145,842)	(1,326,564)
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	678,569	155,944
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	(292,033)	(292,586)
<b>Татварын өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>4,547,988</b>	<b>1,427,115</b>
Орлогын татварын зардал	(623,171)	(186,340)
<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>3,924,817</b>	<b>1,240,775</b>
Бусад дэлгэрэнгүй орлого	6,700,921	830,637
Бусад дэлгэрэнгүй орлогын нэмэгдэл	6,076,453	736,222
Хэрэгжсэн олз	624,468	94,415
<b>Нийт дэлгэрэнгүй орлого</b>	<b>10,625,738</b>	<b>2,071,412</b>
<b>Нэгж хувьцаанд ногдох ашиг</b>	<b>0.014</b>	<b>0.004</b>

"Ард кредит ББСБ" ХК  
Хураангуй санхүүгийн тайлан  
2021 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)

## Өмчийн өөрчлөлтийн тайлан

Мянган төгрөгөөр	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2020 оны 1 сарын 1-ний үлдэгдэл</b>	<b>2,800,000</b>	-	<b>4,048,467</b>	-	<b>3,843,962</b>	<b>10,692,429</b>
Нягтлан бодох бүртгэлийн алдааны залруулга	-	-	-	240,731	(240,731)	-
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>2,800,000</b>	-	<b>4,048,467</b>	<b>240,731</b>	<b>3,603,231</b>	<b>10,692,429</b>
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	-	-	1,240,775	1,240,775
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	830,637	-	830,637
Өмчид гарсан өөрчлөлт	-	(64,396)	(354,175)	-	-	(418,571)
Ногдол ашиг	-	-	-	-	(1,092,000)	(1,092,000)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	(94,415)	94,415	-
<b>2020 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>2,800,000</b>	<b>(64,396)</b>	<b>3,694,292</b>	<b>976,953</b>	<b>3,846,421</b>	<b>11,253,270</b>
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	-	-	3,924,817	3,924,817
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	7,053,406	-	7,053,406
Өмчид гарсан өөрчлөлт	-	64,396	1,648,331	-	-	1,712,727
Ногдол ашиг	-	-	-	-	(986,472)	(986,472)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	(976,953)	624,470	(352,483)
<b>2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>2,800,000</b>	-	<b>5,342,623</b>	<b>7,053,406</b>	<b>7,409,236</b>	<b>22,605,265</b>



"Ард кредит ББСБ" ХК  
Хураангуй санхүүгийн тайлан  
2021 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)

# Мөнгөн гүйлгээний тайлан

Мянган төгрөгөөр	2021	2020
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>124,274,280</b>	<b>55,347,645</b>
Харилцагчдад олгосон зээлийн эргэн төлөлт /үндсэн зээл/	68,006,439	39,048,119
Итгэлцэл, татан төвлөрүүлсэн хөрөнгө	44,428,924	9,017,906
Зээлийн хүүгийн орлого	7,986,407	5,175,231
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	2,924,745	1,550,763
Бусад үйлчилгээний орлого	927,765	555,626
<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>(129,432,407)</b>	<b>(53,720,621)</b>
Харилцагчдад олгосон зээлд төлсөн	(84,990,850)	(42,113,672)
Итгэлцэл татан төвлөрүүлсэн хөрөнгө төлөлт	(36,210,940)	(6,933,486)
Итгэлцлийн үйлчилгээний хүүгийн зардалд төлсөн	(1,671,947)	(1,136,933)
Үндсэн ба нэмэгдэл цалинд төлсөн	(759,903)	(754,937)
Түрээс, менежментийн зардалд төлсөн	(790,679)	(321,050)
Аудитын төлбөр, мэргэжлийн зөвлөгөө үйлчилгээний мөнгө	(29,125)	(294,280)
Татвар, даатгалд төлсөн	(1,125,260)	(280,767)
Бондын хүүгийн зардалд төлсөн	(465,501)	(265,301)
Зохицуулалтын үйлчилгээний хураамжид төлсөн мөнгө	(21,940)	(109,744)
Нийгмийн даатгалын шимтгэлд төлсөн	(236,552)	(105,460)
Шатахуун, холбоо, интернет, сэлбэг хэрэгсэлд төлсөн	(37,969)	(76,947)
Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хүүгийн зардалд төлсөн	(508,101.0)	(18,985)
Бичиг хэргийн зардал, ариун цэврийн зардалд төлсөн	(32,122)	(18,417)
Албан томилолт, сургалтын зардалд төлсөн	(28,545)	(9,894)
Ажилтнуудад олгосон нөхөн олговор, тэтгэмжид төлсөн	(2,799)	(3,605)
Бусад үйлчилгээнд төлсөн мөнгө	(2,520,174)	(1,277,143)
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(5,158,127)</b>	<b>1,627,024</b>
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>15,183</b>	<b>54,834</b>
Харилцах, хадгаламжийн хүүгийн орлого	18	39,455
Ногдол ашгийн орлого	15,165	15,379
Бусад мөнгөн орлого	-	-
<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>(75,704)</b>	<b>(363,840)</b>
Хөрөнгө худалдан авахад төлсөн мөнгө	(75,704)	(363,840)
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(60,521)</b>	<b>(309,006)</b>

"Ард кредит ББСБ" ХК  
Хураангуй санхүүгийн тайлан  
2021 оны 12 сарын 31-нээр дүүсвэр болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлээ)

# Мөнгөн гүйлгээний тайлан (үргэлжлэл)

Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>19,115,413</b>	<b>5,452,513</b>
Бонд гаргалтаас хүлээн авсан мөнгө	-	2,538,000
Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл	19,115,413	2,914,513
<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>(10,190,331)</b>	<b>(5,394,274)</b>
Банк, санхүүгийн зээлийг төлсөн мөнгө	(5,564,414)	(1,840,636)
Бондын төлбөрт төлсөн мөнгө	(3,100,000)	(1,461,198)
Ногдол ашигт төлсөн мөнгө	(904,655)	(1,092,000)
Үнэт цаас худалдан авахад төлсөн мөнгө	(621,262)	(1,000,440)
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>8,925,082</b>	<b>58,239</b>
<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>3,706,434</b>	<b>1,376,257</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>3,249,682</b>	<b>1,873,425</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>6,956,116</b>	<b>3,249,682</b>

Тодруулга: Ард кредит ББСБ ХК-ийн энэхүү хураангуй санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн эрх бүхий байгууллагын баталсан холбогдох дүрэм, журмын дагуу бэлтгэсэн санхүүгийн байдлын тайлан болон орлогын дэлгэрэнгүй тайлангаас ямар нэгэн зөрүүгүйгээр хураангуйлан бэлтгэсэн болно.









Хүчтэй. Хамтдаа.